



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2024 оны I улирал

БОРООНЫ ДАРААХ МӨӨГШИГ


БОРООНЫ ДАРААХ МӨӨГ ШИГ

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17 хувиар нэмэгдлээ. Эдийн засгийн салбаруудын сэргэлттэй зэрэгцэн чанаргүй зээлийн хэмжээ буурч эхэлжээ. Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн банкны зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Төлбөрийн тэнцэл ашигтай байгаа хэдий ч импортын бараа бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэж байгаа нь валютын нөөцөд дарамт болох эрсдэлийг дагуулж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлт үргэлжилсээр байгаа нь төсвийн орлогыг нэмэгдүүлж, төсвийн тэнцэл ашигтай байх нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Уул уурхай, тээврийн салбарын өсөлтөөс гадна барилга, боловсруулах үйлдвэр болон үйлчилгээний салбар өсөлтэй байгаа нь эдийн засаг 7.8 хувиар тэлэхэд чухал нөлөө үзүүлжээ. Өнгөрсөн оны сүүлээс өвөлжилт хүндэрч мал аж ахуйн салбарт ихээхэн хохирол учирсан нь хөдөө аж ахуйн салбарт сөргөөр нөлөөллөө. Нийлүүлэлтийн гаралтай бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тогтворжиж инфляцын түвшин буурчээ.

Эдийн засгийн үзүүлэлтүүд сайжрахтай зэрэгцэн тооцоо судалгаагүй, үр ашиггүй “Борооны дараах мөөг шиг” олон төсөл, хөтөлбөрүүдийг төрөөс хэрэгжүүлж эхэлбэл эдийн засгийн сэргэлтийг хязгаарлах, цаашлаад дордоход хүргэж болох эрсдэл буйг санах нь зүйтэй.



Иргэдийн цалин, хөлс нэмэгдэхтэй зэрэгцэн хэрэглээний зээлийн өсөлт үргэлжилсээр байна

Цалин, тэтгэврийн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35 хувиар нэмэгджээ. Иргэд цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл түлхүү авч байна.




Онолын
тодорхойлолт



Банкны шинээр олгосон зээл
Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг

Иргэдийн зээл олголт, жил бүрийн I улирал

Их наяд ₮



Иргэдийн зээл

27%

Нэмэгджээ.



2024 оны I
улирлын
гүйцэтгэл

2024 ОНЫ БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Иргэд, аж ахуйн нэгжийг дэмжихэд чиглэсэн зээл олголт нэмэгджээ.



Банкуудын чанаргүй зээлийн багц буурчээ.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна.



Олон нийтэд нээлттэй болсон банкууд 2023 оны ашгаас 483 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний ногдол ашиг хуваарилжээ.



Банкны салбарын санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтүүд олон улстай дүйцэхүйц байна.



Төгрөгийн хадгаламжийн өгөөж нэмэгдсэн нь төгрөгийн хадгаламж нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлээ.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2024 он I улирал

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+26%


Зээлийн үлдэгдэл өсөв.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн салбаруудад олгох зээл нэмэгдсэн нь зээлийн өсөлтийг дэмжлээ.

Банкууд эдийн засгийг дэмжих, салбарын сэргэлтийг хурдасгах зорилгоор иргэд, аж ахуй нэгжид өөрийн эх үүсвэрээр зээл олгосоор байна.


Эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгоор олгож буй бизнесийн зээл нэмэгдэж эхэллээ.



Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн зээлүүд нэмэгджээ.

Уул уурхай болон боловсруулах салбарт олгож буй зээлийн хэмжээ буурчээ.
Барилга, худалдаа, үйлчилгээ болон ХАА-н бизнес эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн зээлийн хэмжээ огцом нэмэгджээ.

Бизнесийн зээл олголт, жил бүрийн I улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг

Шинээр олгосон зээл

37%

өсжээ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээлийн хэмжээ
буурчээ.


7.1%

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо


Зээлийн багцын чанар сайжирч байна.

Карт болон авто машины зээлийн чанаргүйдэл бусад хэрэглээний зээлтэй харьцуулахад өндөр байна. Эдийн засаг сэргэж байгаа нь бизнесийн зээлийн чанар сайжрахад эергээр нөлөөлж байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн I улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн I улирал



Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.


Зээлийн хүү

17%

Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү тогтвортой байна.

Эдийн засгийн салбаруудын сэргэлт, түүнийг даган бодлогын хүү аажмаар буурч байгаа нь зээлийн хүү буурах хүлээлтийг буй болгож байна.




Эдийн засгийн нөхцөл байдал сайжирч төгрөгт итгэх итгэл нэмэгдсэн нь төгрөгийн хадгаламжийг нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад валютын хадгаламж 24 хувиар, валютын харилцах 3 хувиар тус тус буурчээ. Төгрөгийн хадгаламжийн бодит өгөөж эерэг байгаа нь иргэдийн төгрөгийн хадгаламж нэмэгдэхэд нөлөөллөө.

Банкны эх үүсвэр, жил бүрийн I улиралд

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж

39%

НЭМЭГДЭВ

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2023 он I улирал

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив өсөв.

17%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан


Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 7.3 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Банкны салбарын активын өсөлт үргэлжилсээр байна.

Төрийн банкны актив 28 хувиар, ХасБанкны актив 25 хувиар, ХХБ актив 22 хувиар тус тус өсжээ.

Банкуудын актив жил бүрийн I улирал


Их наяд ₮



Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

ХХБ эх үүсвэр 2.1 их наяд, Голомт банкны эх үүсвэр 1.7 их наяд төгрөгөөр тус тус өсжээ. Бусад системийн нөлөө бүхий банкуудын эх үүсвэр нэмэгджээ.

Банкуудын эх үүсвэр жил бүрийн I улирал



Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр нэмэгдэв.

20%

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс
гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний
өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг
хэлдэг.

Банкуудын өөрийн
хөрөнгийн хүрэлцээний
дундаж

18%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан


Банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээ өндөр байна.

Банкууд эдийн засгийн голлох салбаруудын өсөлтийг дэмжих хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкууд өөрийн ашгаас 480 тэрбум төгрөгтэй тэнцэх ногдол ашиг хуваарилжээ.

Банкууд эдийн засгийн өсөлт, гол салбаруудын идэвхжлийг дэмжихэд хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн I улирал




2022	2023	2024	2022	2023	2024	2022	2023	2024	2022	2023	2024	2022	2023	2024
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Банкуудын олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байна.
ХасБанкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт буурсан хэдий ч хөрвөх чадвар өндөр хэвээр байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн I улирал



2022	2023	2024
Хаан		
2022	2023	2024
ХХБ		
2022	2023	2024
Голомт		
2022	2023	2024
Төрийн банк		
2022	2023	2024
Хас		

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж

41%

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2023 оны I улирал: Эдийн засгийн өсөлт 7.8 хувьтай гарлаа. Уул уурхай, түүнийг дагасан тээвэр, логистик болон худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт үргэлжлэхтэй зэрэгцэн барилга, боловсруулах салбарын сэргэлт эрчимжиж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүллээ. Өнгөрсөн оны сүүлээс өвөлжилт хүндэрч мал аж ахуйн салбарт ихээхэн хохирол учирсан нь хөдөө аж ахуйн салбарт сөргөөр нөлөөллөө. Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцын түвшин тогтворжиж байна.


Төлөв байдал: Эдийн засгийн үзүүлэлт ерөнхийдөө сайн байна. Гэвч уул уурхайн гол бүтээгдэхүүн болон нүүрс болон цайрын хүдэр, баяжмалын дэлхийн зах зээл дээрх үнэ буурсан нь экспортын орлого буурах, валютын орох урсгал тасалдах эрсдэлийг дагуулж байна. Түүнчлэн, эдийн засгийн салбар сэргэхтэй зэрэгцэн импортын бараа бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэж буй нь валютын гарах урсгалыг нэмэгдүүлж, валютын нөөцөд дарамт учруулах төлөвтэй байна.

2024 оны эхний улиралд эдийн засаг 7.8 хувиар өсөв.

Уул уурхай, тээвэр болон худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт үргэлжилсээр байна.

Боловсруулах болон барилгын салбар сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтөд зэрэг нөлөө үзүүллээ.

Өнгөрсөн оны сүүлээс цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбарт ихээхэн хохирол учирсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө.



Гадаад худалдааны тэнцэл эхний улиралд 1.2 тэрбум ам.долларын ашигтай байна.

Уул уурхайн гаралтай түүхий эдийн биет хэмжээ өсөлттэй байгаа хэдий ч нүүрс, цайрын хүдэр болон баяжмалын дэлхийн зах зээл дээрх үнэ буурсан нь экспортын хэмжээ үнийн дүнгээр буурахад нөлөөлжээ.

Импортын бараа, тэр дундаа хөрөнгө оруулалт болон нефтийн бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн нь импортын өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ.


Оны эхний гурван сард суудлын авто машины импорт өмнөх оноос 2.4 дахин нэмэгдсэн байна.

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн бууралт нь экспортын өсөлтийг саарахад нөлөөлжээ.


Хувиар



Хөрөнгө оруулалтын болон нефтийн бүтээгдэхүүний өсөлт нь импортын хэмжээг нэмэгдэхэд нөлөөлжээ.




Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ буурсан хэдий ч худалдааны тэнцэл ашигтай байна.




Төлбөрийн тэнцэл 373 сая ам.долларын ашигтай байна.

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа нь санхүүгийн дансны ашиг нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлжээ.
- Импортын бараа бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдсэн нь урсгал данс алдагдалтай гарахад нөлөөлжээ.
- Төгрөгийн бодит ханш чангарч манай улсын бараа бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад үнэтэй болж байна.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш




Төлбөрийн тэнцэл ашигтай гарчээ.



Инфляц аажмаар буурч хадгаламжийн бодит өгөөж нэмэгдэж байна.

Нийлүүлэлтийн гаралтай инфляцын түвшин аажмаар буурсан нь хадгаламжийн бодит өгөөжийг нэмэгдүүлж байна. Төгрөгт итгэх итгэл нэмэгдэж, үүнийг дагаад төгрөгийн хадгаламж нэмэгджээ.




Төсвийн тэнцэл 656.6 тэрбум төгрөгийн ашигтай байна.


Эдийн засгийн салбаруудын сэргэлт, түүхий эдийн бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн нь төсвийн орлогын өсөлтийг дэмжлээ. Төсвийн урсгал зардал, тэр дундаа цалин, хөлсний зардал нэмэгдсэн нь төсвийн зардлын дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. Үндсэн тэнцэл ашигтай гарч, төсвийн алдагдлын дарамт буурч байна.

Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 51 хувиар нэмэгджээ.


ДНБ-д эзлэх хувиар



Нийт төсвийн зарлага өмнөх оны мөн үеэс 38 хувиар нэмэгджээ.



Төсвийн алдагдал буурчээ.




Манай улсын санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтүүд бусад улсуудтай харьцуулахад харьцангуй сайн байна.

- Банк болон зээлдэгчийн эрсдэл бууруулах санхүүгийн байгууллагуудын (даатгал, ЗБДС гэх мэт) оролцоог нэмэгдүүлэх.
- ЖДҮҮ нарын онцлогт тохирсон хямд эх үүсвэртэй зээлийн бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх.
- Технологит суурилсан зээлийн бүтээгдэхүүний хүртээмжийг сайжруулах.
- ЖДҮҮ нарт зориулсан зээлийн мэдээллийн сан, кредит скоринг хөгжүүлэх.

Банкны салбарын хүртээмжийн үзүүлэлтээр өндөр хөгжилтэй улсуудтай ижил түвшинд байна.

Нийт насанд хүрсэн хүн амын 98% нь банканд данстай.

Насанд хүрсэн хүн амын 97% нь дижитал төлбөр тооцоог ашиглаж байна.



Эх сурвалж: Global Findex Database - 2021



САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ



Санхүүгийн хүртээмжийн тухай

Банкны салбар дахь санхүүгийн хүртээмж

Санхүүгийн хүртээмжийн гүнзгийрэлд анхаарал хандуулах хэрэгцээ шаардлага өндөр байна.



15%

банкаар тогтмол үйлчлүүлдэггүй



29%

зайнаас үйлчилгээ авдаггүй



6%

онлайн хадгаламжийн үйлчилгээ ашигладаг



10 хүн тутмын 9

нь яаралтай санхүүгийн хэрэгцээ гарвал найз, нөхөд гэр бүлдээ ханддаг



53%

санхүүгийн байгууллагад зээлтэй



72%

хадгаламжгүй




САНХҮҮГИЙН
ХҮРТЭЭМЖ



Санхүүгийн
хүртээмжийн тухай

Банкны салбар дахь
санхүүгийн хүртээмж

100,000 хүнд оногдох банкны салбар, нэгжийн тоо өндөр байна.




САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ



Санхүүгийн
хүртээмжийн тухай


Банкны салбар дахь
санхүүгийн хүртээмж

Дижитал шилжилт ЖДҮҮ эрхлэгчдийн төлбөр тооцоог хялбарчилжээ.




80%

нь интернэт банктай байна



10%

нь карт эзэмшиж байна.



ПОС хэрэглэгч ЖДҮҮ эрхлэгчид

20% нэмэгджээ.



20%

цахим худалдаа нэмэгджээ.

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ



Санхүүгийн
хүртээмжийн тухай

Банкны салбар дахь
санхүүгийн хүртээмж

ЖДҮҮ олгогдож буй зээлийн хэмжээ сонгосон улсуудтай харьцуулахад боломжийн түвшинд байна.




САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ



Санхүүгийн
хүртээмжийн тухай

Банкны салбар дахь
санхүүгийн хүртээмж



Худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮҮ эрхлэгч иргэдэд зээлийн дийлэнх хэсгийг олгож байна.



САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ



Санхүүгийн хүртээмжийн тухай

Банкны салбар дахь санхүүгийн хүртээмж

